



БОЛОВСРОЛ,  
ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ



БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ  
БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ

# ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ-2024 СУУРЬ БОЛОВСРОЛ



# ТҮҮХ

*ХУВИЛБАР А*

Аймаг / дүүрэг: .....

Сум / сургууль: .....

Анги / бүлэг: .....

Сурагчийн овог: .....

Сурагчийн нэр: .....

Сурагчийн код: .....




### САНАМЖ

- Даалгаврыг 40 минутад гүйцэтгээрэй.
- Даалгавар тус бүрээс зөвхөн нэг хариултын хувилбарыг сонгож, хариултын хуудсанд зааврын дагуу балын харандаагаар будаарай.

1. Цэгийн оронд тохирох утгыг нөхнө үү.  
1686 онд Өндөр гэгээн Занабазар ..... үсгийг зохиожээ.  
А. Тод үсэг                      В. Соёмбо үсэг                      С. Али гали                      D. Ганжуур
2. Бурхны шашин дэлгэрсэнтэй холбоотойгоор монголчуудын амьдралд ямар өөрчлөлт гарсан бэ?  
А. Жилийн дөрвөн улирал, аж байдалдаа зохицсон нүүдлийн мал аж ахуй эрхлэх болсон  
В. Эсгий ширж хээ угалзаар чимэглэх болсон  
С. Гэрийн тооно авсаархан болж, нүүх, тээвэрлэхэд улам тохиромжтой болсон  
D. Гэр дотроо бурханы хөргийг тахиж тавиад, идэж уухдаа дээжийн нь өргөдөг болсон
3. Монгол бичиг, Манж бичиг, Манжийн хууль, цааз зэргийг зааж сургадаг нь сургуулийн ямар төрөл хэлбэр вэ?  
А. Гэрийн сургууль                      В. Шашны сургууль  
С. Албаны сургууль                      D. Цэргийн сургууль
4. XVI зууны 60-аад оноос XVII зууны 60-аад он хүртлэх 100 жилийг Японы түүхэнд юу гэж нэрлэдэг вэ?  
А. Алтан үе                                      В. Дайтагч улсуудын үе  
С. Аугаа их гурвал                              D. Хаант улсын үе
5. Жу Юань Жан хятадын босогчдыг толгойлж, Юань улсын эсрэг тариачдын их цэргийг байгуулж, 1368 онд Мин улсыг байгуулж өөрийгөө юунд өргөмжилсөн бэ?  
А. Шаньюй                      В. Ван                      С. Шах                      D. Хуанди
6. Цэгийн оронд тохирох утгыг нөхнө үү.  
1592 оноос Япончууд Чусоны ихэнх газар нутгийг эзлэн авав. Гэвч Чусоны ард түмэн үүнийг эсэргүүцэн ..... дайчдын бүлгүүд, сайн дурын цэргийн хүчнийг бий болгож тэмцжээ.  
А. засаглан хааж                                      В. газрын гэрээ  
С. жад авлах    D. үнэн хэргийн төлөө
7. Османы эзэнт улсын II Махмуд Константинополыг эзлэн аваад, нийслэлээ болгож, нэрийг нь юу гэж өөрчилсөн бэ?  
А. Истанбул                      В. Дамаск                      С. Анкара                      D. Жерусалим
8. Итали гаралтай Христофер Колумб 1492 онд гурван хөлөг онгоц, 90 хүн бүхий багийг ямар улсын тусламж, дэмжлэгийг авч аялалдаа гарсан бэ?  
А. Итали                      В. Португал                      С. Испани                      D. Англи

9. Фернан Магелланы аялаж явахдаа нээсэн газрууд аль нь вэ?  
А. Ногоон хошуу, Гвиней, Энэтхэг Калькутта  
В. Канарын арлууд, Карибын тэнгисийн Багамын Сан-Сальвадор  
С. Ногоон хошууны арал, Рео-де-Жанейрогийн булан, Номхон далай  
D. Австрали, Шинэ Зеланд, Филиппиний арал
10. Доорх газрын зурагт Португалын колони эзэмшлийг хэдийн тоогоор тэмдэглэсэн байна вэ?




11. “Төлсөн зоос нь өргөлийн хайрцагт жингэнэн ороход сүнс нь ариутгалын орноос диваажин руу нисэн одно” уг гэж хэн хэлсэн бэ?  
А. Гэгээн Павел      В. Иохан Тецель      С. Мартин Лютер      D. Жан Кальвин
12. Цэгийн оронд тохирох нэрийг нөхнө үү.  
.....1559 онд протестант шашны номлогчдыг бэлтгэх, Женевийн академийг үүсгэн байгуулжээ.  
А. Ромын пап X Лео      В. Мартин Лютер      С. Жан Кальвин      D. Иохин Тецель
13. Доорх зурган дээрх бүтээлийг хэн хийсэн бэ?



Нисдэг машин

- А. Уильям Гарвей  
В. Ж.Кардано  
С. Николас Коперник  
D. Леонардо Да Винчи

14. Доорх зурган дээрх уурын хөдөлгүүрийг Томас Ньюкомэн 1712 онд зохион бүтээснээр юунд ашиглах болсон бэ?



- A. Уурхай, нэхмэлийн болон бусад үйлдвэрийн янз бүрийн машин ажиллуулах
- B. Уурхайн гүний усыг шахан гаргахад
- C. Сүйх тэрэг, галт тэрэгний зүтгүүрийг бий болгоход
- D. Химийн элементүүдийг гаргаж авахын тулд

15. XVIII зуунд Их Британд хүн ам ихээр өсөж хүмүүсийн даавуугаар хийсэн хувцасны хэрэгцээг гар үйлдвэрлэлээр хангаж дийлэхгүй байсан учир тэд аж үйлдвэрт ямар арга хэмжээ авсан бэ?

- A. Нэхмэлийн суурь машин бүтээж хувцсыг олноор нь хийх болсон
- B. Энэтхэг, Хятадаас бөс даавуу олноор оруулах болсон
- C. Даавуун хувцас өмсөхөө больсон
- D. Гадаадаас ажиллах хүчин авчруулах болсон

16. Олон жилийн ажиглалт, судалгааныхаа үр дүнд туурвисан “Зүйлийн үүсэл” алдарт бүтээлээ 1859 онд гаргасан Британий байгаль судлаач аль нь вэ?

- A. Майкл Фарадей
- B. Жосеф Листер
- C. Чарлз Дарвин
- D. Вэндэлл Холмс

17. Техник, технологийн шинжлэх ухаанд 1831 онд Америкт Сирьюс Хол МакКормик 3 хүний ажлыг гүйцэтгэдэг механик ямар бүтээл гаргасан бэ?

- A. Ургац хураагч
- B. Загас баригч
- C. Өвчин намдаагч эм
- D. Бордоо

18. Том Эдисоны зохион бүтээсэн бүтээл нь хотуудыг үзэмжтэй болгож, хүмүүсийг шөнө дөлөөр ажиллах боломжыг нэмэв. Уг бүтээл ямар бүтээл вэ?

- A. Хөдөлгөөнт зураг
- B. Телефон утас
- C. Унадаг дугуй
- D. Цахилгаан дэнлүү

19. Ричард Трэвитик 1804 анхны төмөр замын зүтгүүрийг амжилттай ажиллуулав. Уг зүтгүүр нь тухайн үедээ ямар амжилт үзүүлсэн бэ?

- A. Төмөр замаар 160 км/ц хүртэл хурдалсан
- B. Зорчигч тээврийн зам дээр 50 км/ц хүртэл хурдалсан
- C. 10 тонн хүнд цутгамлыг 15 км зайд зөөсөн
- D. 10 хүнийг 10 км зайд зөөсөн

20. Амарсанаа “эзэн хаанд бараалхана” гэж гараад Алтайн цаана Өрөнгө голд хүрч ирмэгцээ шадар 300 цэргээ удирдан 1755 оны 9-р сарын 24 бослого гаргав. Амарсанаагийн бослого Монголын аль хэсэгт гарсан бэ?


- A. Өвөр Монгол
- B. Халх Монгол
- C. Ойрад Монгол
- D. Буриад Монгол

21. 1691 онд Манжид эзлэгдсэн улсыг хэдийн тоогоор газрын зурагт тэмдэглэсэн байна вэ?



A. 1      B. 2      C. 3      D.4

22. Дараах бүдүүвчийн цэгийн оронд тохирох хариултыг нөхөж бичнэ үү.



A. Буриад      B. Барга      C. Халх Монгол      D. Халимаг

23. Монголчуудын “үндсийг таслах, шашныг устгах” бодлого гэж ямар бодлого, үйл ажиллагааг нэрлэж байна вэ?

- A. Манжийн төрийг эсэргүүцэн босох бодлого
- B. Манжийн төрөөс монголын талаар явуулсан бодлого
- C. Тусгаар тогтнолынхоо төлөө тэмцэх бодлого
- D. Хятадын зүгээс монголд хэрэгжүүлсэн бодлого

24. 1906 онд Бээжин хотноо “Нүүдлийн иргэдийн хэргийг эрхлэх хороо” байгуулав. Уг үйл явдал хэддүгээр зуунд болсон бэ?

- A. XVIII зуунд      B. XIX зуунд      C. XX зуунд      D. XXI зуунд

25. Манж Чин улсад капитализмын хөгжил түргэсэж, улмаар гадаадын эсэргүүцсэн бослого дэгдсэн ч 1901 онд дарагдав. Уг үйл явдал хэддүгээр жаранд болсон бэ?

- A. 13-р жаранд      B. 14-р жаранд
- C. 15-р жаранд      D. 16-р жаранд

